

2000 оны 4-р сарын 25 -нд хуралдсан
МЛАН-ын VI Бүгд хурлаар хэлэлцэж батлав.

**2000 оны Улсын Их Хурлын сонгуульд баримтлах
МЛАН-ын хөтөлбөр**

Шинэ сонгууль нь шинэ мянган жилийн гараан дээр болж байгаагаараа Шинэ эрхийн угтлаг болж байгааг ухамсарлан,

Шинэ сонгууль нь ардчиллыг цоо шинэ шатанд гаргах түүхэн Шинэ үед болж байгааг мэдрэн,

Шинэ сонгуулиар Монгол улсаа төрийн саруул ухаанаар хөтлөн залах чадвартай түшээ нараа тодруулах Шинэ сонголт хийх гэж буйг ойлгон,

Шинэ сонгуулиар хөгжлийн шинэ гарааг эхлүүлэн Шинэ Монголд хүргэх түүхэн зорилтуудыг тодорхойлон

Шинэ үе

Шинэ эрин

Шинэ сонголт

Шинэ Монгол

Уриан дор

Монголын Либерал Ардчилсан Нам 2000 оны УИХ-ын Сонгуулийн хөтөлбөрөө сонгогч түмэндээ толилуулж байна.

МЛАН нь ард олныхоо эрх ашгийг илэрхийлсэн багц зорилтуудыг хэрэгжүүлэхдээ:

- Ард иргэд асуудлаа шийдвэрлэхийн тулд эвлэлдэн нэгдэж, өөрсдөө бат итгэсэн засаг төрөө сонгодог иргэний нийгмийг төлөвшүүлэх
- Төр нь иргэдийнхээ эрхийг тууштай хамгаалдаг, хүчирхийлэл, аллага хядлага гаргах үүд хаалгыг бүрэн хаасан, төрийн түшээ нар нь худал ярьж, хулгай хийдэггүй, гэмт этгээдүүдэд үйлчилдэггүй тийм соёлжингуй төр засгийн тогтолцоо бий болгох
- Ард иргэдийн нь цалин хөлс болон ажлын байр байнга өсөн нэмэгдэж байдаг нийгмийн чиг баримжаа бүхий, өрсөлдөх чадвартай зах зээлийн эдийн засагтай улс орон болгох явдлыг үндэс болгож байна.

Эрх зүйт төрийн бүтцийг бэхжүүлэх зорилтууд

МОНГОЛЫН ЛИБЕРАЛ АРДЧИЛСАН НАМ эрх зүйт төр, иргэний төрийн үзэл санаа, түүний оновчтой бүтэц тогтолцоог бүрдүүлж бэхжүүлэхийн төлөө байна. Өнөөдөр Монгол орны хувь заяаны зангилаа асуудал болсон эрх зүйт төрийн үзэл санааг хамгаалж, хөгжүүлэхийн тулд:

Нэгдүгээрт, иргэн хүний тухайд хуулиар шууд хориглоогүй бүхэн түүнд нээлттэй байх, харин түшмэдүүдийн тухайд хуулиар зөвшөөрсөн зүйлийг зөвхөн ёс журмаар нь гүйцэтгэн хэрэгжүүлдэг байх зарчмуудыг дээдэлдэг болгох

Хоёрдугаарт, төрийн өндөрлөгүүдийн хооронд эрх мэдлийг хуваарилахдаа түүнийг урвуулан ашиглах үүд хаалгыг бүрэн хаана. Төр засаг өөрийгөө шийтгэж болохгүй гэдэгт итгэх бус, харин шийтгэл ч хүлээх ёстой гэдгээ мэдэрдэг байх зарчмыг хэрэгжүүлэх

Гуравдугаарт, гүйцэтгэх засаглалаас хараат бус, шударга, олон түмний итгэл үндэтгэл хүлээсэн шүүх засаглал тогтоохын төлөө хатуу зогсох зарчмуудыг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Үндсэн хуулийн шинэчлэлт хийх

1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн Хуулинд ихээхэн нэмэлт өөрчлөлт хийх шаардлагатай нь өнгөрсөн хугацаанд нэгэнт батлагдав. Нэн ялангуяа засаг төрийн эрх мэдэлтнүүдээс эрх дураар авирлах, хээл хахууль, авилгалд автагдах явдал газар авав. Парламент болон гүйцэтгэх засаглалд үл тохирох хүмүүс тэдгээрт олноор шургалан орж байгаа нь нэн аюултай .

МЛАН Үндсэн Хуулинд нэмэлт өөрчлөлт хийх явдлыг эцсийн зорилгоо болгохгүй, харин түүнийг нийгмийн өмнө засаг, төрийн /хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглалын/ хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх үндсэн нөхцөл хэмээн үзэж байна. Үүний тулд эн түүрүүнд:

- хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглалын хоорондын бүрэн эрхийг бодитойгоор зааглаж хязгаарлах, засаг төрийн нэг байгууллага нь бусдынхаа бүрэн эрхийг эзэмших боломжийг хязгаарласан заалтууд оруулах
- Ерөнхийлөгчийн бүрэн эрх, хариуцлагыг нарийвчлан тогтоох
- Парламентын хяналтын бүрэн эрхийг улам чангатгах
- Шүүхийн хараат бус байдлыг жинхэнээр нь хангаж, шүүхийн шийдвэрийг гарцаагүй биелүүлэх нөхцөл, механизмыг бүрдүүлэх, шүүхийн ажилтныг авилгал, хээл хахуульд өртөхөөс бүрэн сэргийлэхэд тус тус чиглүүлэх болно.

Бүсчилсэн хөгжлийн бодлого хэрэгжүүлэх

Одоогоор манай улсын хувьд бүсчилсэн хөгжлийн бодлогыг идэвхтэй явуулахгүй бол Монгол Улсад үр нөлөө бүхий эдийн засгийн бодлого явуулах боломжгүй гэж МЛАН үзэж байна.

Монгол Улсын хөгжлийг түргэсгэхийн тулд эдийн засгийн макро бүсүүдийн түвшинд зааг ялгавартай бодлого явуулж, хөдөөгийн хөгжлийг, түүний дотор алслагдсан бүс нутгуудын хөгжлийг дэмжих замаар хүн амын амьдралын түвшний хот, хөдөөгийн илгааг арилгах зорилтыг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүний тулд эн түүрүүнд:

- Монгол Улсыг бүсчилэн хөгжүүлэх бодлогын үндсэн чиглэлийг агуулсан үзэл баримтлалыг Улсын Их Хурлаар хэлэлцэж батлах.
- Бүсчилэн хөгжүүлэх зорилтуудыг тусгасан улс орны тогтвортой хөгжлийн урт, дунд хугацааны хөтөлбөрүүдийг боловсруулж хэрэгжүүлэх талаар Засгийн газраас шийдвэртэй алхам хийх.
- Бүсчилсэн хөгжлийн бодлогыг удирдлага, зохион байгуулалтаар хангах үүднээс удирдлагын оновчтой тогтолцоо бүрдүүлэх.
- Бүсчилсэн хөгжлийн бодлогыг дэмжих зориулалт бүхий дотоод, гадаад хөрөнгийн эх үүсвэрээс бүрдсэн "Бүс нутгийн хөгжлийн сан" байгуулж ажиллуулах

Нутгийн өөрөө удирдах ёсыг бэхжүүлэх

сонгогчид гишүүнээ УИХ-аас эгүүлэн татдаг хууль санаачлан хэрэгжүүлэхийн төлөө байна.

Манай улсын нийт сонгогчдын дийлэнх нь нам бусчууд байдаг онцлогийг харгалзан төр засгийн өндөрлөгүүдийн бүрэлдэхүүнийг сэлбэхдээ нам бусчуудын оролцоог илүү өргөн тэлэх механизм бүрдүүлэхийн төлөө байна.

Төр, нийгэмд бодитой үр ашиг өгч чадахаа үйл ажиллагаагаараа харуулсан төрийн бус байгууллагуудад төрийн тодорхой үүргүүдийг итгэл өгөн гүйцэтгүүлэх хүрээг өндөр өргөтгөхийн төлөө байна.

МАН-ын засгийн хүрээнд тавих үндсэн зорилтууд

МАН-аас Монгол Улсын эдийн засгийг хөгжүүлэх зорилтыг дэвшүүлэн тавихдаа төрийн төсвийг бүрдүүлэхэд чиглэсэн албан ёсны секторын хөгжлийг дэмжих замаар эдийн засгийн өсөлтийг хангах, үүний зэрэгцээ далд эдийн засгийг хавчин хязгаарлах явдлыг өргөжин болгож байна.

МАН-ын эдийн засгийн хөтөлбөрийн гол үндсүүд нь:

Төр засгийн бодлогод итгэх итгэлийг буцааж төрүүлэх. Төр засагт итгэх иргэдийн болон ажил хэрэгч хүмүүсийн итгэл нь ямар ч эдийн засгийн хөтөлбөр амжилттай дэмжих урьдчилсан нөхцөл мөн. Итгэл бол гадаадын хөрөнгө оруулалтыг татах ба гадаадын бага хүүтэй зээлийг хязгаарлагдмал хэмжээнд авч ашиглах арга мөн. Энэ нь үндэсний валютыг бэхжүүлэх, банк санхүүгийн системийг зөвөөр ажиллуулах, банкны зээлийг бодит салбарт олгох боломж өгнө хэмээн үзэж байна.

Итгэлийг төрүүлэхдээ:

- Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг улс орон, ард түмний эрх ашигт нийцүүлэх
- Үүнийг ил тод илэрхийлэх
- Бодит төсөв бүрдүүлэх
- Төрийн өмч болон улсын мэдэлд байгаа нөөцийг зөв ашиглах
- Хөрөнгө оруулагчидтай шударга, тогтвортой харилцах зэрэг олон боломжийг ашиглана.

Татварыг бууруулж, татварын системийг шударга, хялбар болгох

Татварын дарамтыг багасгаснаар далд эдийн засгийг шахаж, эдийн засгийн өсөлтийг хангана. Татварын системийг шударга хялбар болгосноор татварт тавих хяналтыг бууруулна. Байгууллагын орлогын албан татварыг ашиг, элэгдэл, хорогдлын шимтгэл, зарим үйлдвэрийн фонд буюу цэвэр орлогоос тооцсноор татварын алба, байцаагчийн зүгээс шалгалт, шахалт, дарамт үзүүлэхгүйгээр зөвхөн тайлан балансаар тооцох боломжтой. Татвар төлөгч татвараа нуух боломжгүй. Татварын хувийг 5% болгосноор татвар нуух шаардлагагүй болно. Цалингаас хүн амын орлогын албан татвар авдаггүй болгоно. НӨТ-ийн хувийг 61,5%-иар бууруулна. Гаалийн ба онцгой татварыг дотоодын үйлдвэрлэлийг дэмжихэд чиглүүлнэ.

Татварын боллого нь татвар төлөгчийн аж ахуйг аль болох томосгож, шинэ хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг бүрдүүлэхэд чиглэгдэх ёстой гэж үзнэ. Татварын тайланг аж ахуйн үйл ажиллагааны тайлантай нэгэн зэрэг гаргаж байхаар хуулийг өөрчилнө.

Госвийн заривчлалтын зохистой журам нэвтрүүлэх. Үүний тулд:

- Госвийн сахилгыг бэхжүүлэх
- госвийн бүх дансыг санхүүгийн албанд шилжүүлэх
- улсын захиалга бараа авах тендерийн журам нэвтрүүлэх
- госвийн ба санхүүгийн баримтын шалгалт хийх гэх мэт
- Томоохон татвар төлөгчдийн санхүүгийн үйл ажиллагааны журам нэвтрүүлэх
- Хууль тогтоох ба гүйцэтгэх засаглал дахь авилгалтай тэмцэх
- Төшөөрсөн төсвийн хуваарилалт, түүнээс орон нутгийн төсвийн хуваарилалтад тавих

Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагууд бол иргэдээс эдийн засаг, нийгмийн хүчээр үр ашигтайгаар өөрсдөө зохион байгуулахад ашиглаж буй иргэний нийгмийн гурь институт мөн. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагууд нь хүмүүсийн амин тухал тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэж чадна. Харамсалтай нь одоогоор энэхүү зорилгыг бүрэн ашиглаж чадахгүй байна. Энэ чиглэлд авах арга хэмжээнүүд нь:

- Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудын Үндсэн Хуулиар олгогдсон эрх зүйлсийг бүрэн хэрэгжүүлж, ялангуяа Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлуудын үйл ажиллагааг ёс төдий байдлаас гаргаж, тэдгээрийн биеэ даасан байдал, ажил хэрэгч чанарыг дээшлүүлэн, боловсон хүчний чадавхийг нь нэмэгдүүлэх.
- Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудыг эдийн засгийн талаар бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, юуны өмнө эдийн засгийн хөшүүргүүдийг /зээл, татвар зэрэг/ зүй тохистой хэрэглэх арга хэмжээ авах
- Орон нутгийн засаг захиргааг нэг буюу цөөн бүлэг хүний гарт төвлөрүүлэх, хүн амын эрэлт хүсэлтийг хааж боогдуулах, иргэдээс хүссэн мэдээллийг таслах саатуулах, санхүүгийн үйл ажиллагааг нууж хаах зэрэг зохисгүй үйл ажиллагааг таслан зогсооно.

Гэмт хэрэгтэй хийх тэмцэл

Гэмт хэрэг өсөж байгаагийн үндсэн шалтгаан нь хүн амын өргөн давхаргын нийгэм, эдийн засгийн нөхцөл муудсан, үзэл, суртал, ёс суртахууны чиг баримжааны систем эвдэрсэн, хууль тогтоомжууд бүрэн гүйцэд боловсроогүй, хууль сахиулах байгууллагуудын зохион байгуулалт, үйл ажиллагаа шинэ нөхцөлд зохицож ядан байгаагаар холбоотой байна. Гэмт хэрэгтэй хийх тэмцлийг идэвхжүүлэхийн тулд:

- Өлсгөлөн, ажилгүйдэлтэй шаргуу тэмцэх, гэр бүлийг бэхжүүлэх, боловсролын системийг сайжруулах, соёл, ялангуяа хүүхэд, залуучуудын соёл, амралтанд хүчтэй анхаарал тавих чиглэлүүдэд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх
- Шүүх болон хүчний байгууллагуудын бүтэц, үйл ажиллагаа, тэнд ажиллаж буй боловсон хүчний ахуй нөхцөлийг сайжруулах чиглэлүүдэд гүн гүнзгий өөрчлөлт шинэчлэлт хийх
- Гэмт хэргийн эсрэг явуулах тэмцэлд улс төрний удирдлагын зүгээс хатуу байр суурь баримтлах

Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн эрх чөлөөг хаиггах

Олон нийтийн мэдээллийн чөлөөт хэрэгслүүд нь Монгол оронд ардчиллыг тогтоон хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан юм. Гэвч олон түмэн санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг бүрэн утгаар нь хэрэгжүүлэх талаар ашигдалтай бус хэвээр байна. Энэхүү хүчирхэг хэрэгслийг олон нийтэд суртал ухуулга хийх хэрэгсэл болгон хувиргах явдал үргэлжилсээр байна. Учир нь түүнийг төр засаг барьж буй улс төрийн хүчнүүд, гүйцэтгэх засаглалын байгууллагууд хатуу хяналтандаа барих явдал үргэлжилсээр байна. Ийм учраас МЛАН:

- төр, засгийн байгууллагууд хэвлэл, мэдээллийн байгууллагуудыг байгуулах юмуу, аль эсвэл тэдгээр байгууллагын хувьцаа эзэмших явдлыг бүрэн зогсоох
- Хэвлэл мэдээллийн бүхний л хэрэгсэлд тэгш үндсэн дээр татварын болон бусад хөнгөлөлт үзүүлэх
- Сэтгүүлчид мэдээлэл авах, мэдээллээ олон түмэнд хүргэх эрх чөлөөг тууштай хамгаалж хөгжүүлэхийн төлөө байна.

Төр, олон түмний холбоог бэхжүүлэх

Иргэний нийгэм хүчирхэг байхын үндэс нь өргөн олон түмэнтэй тогтоосон холбоог өргөтгөх, төр барих үйл хэрэгт аль болох өргөн олон түмнийг оролцуулахад оршино. Манай нам:

- УИХ-ын гишүүд жилээс илүүгүй хугацаанд тойргийн сонгогчидтойгоо тогтмол уулзаж, тайлангаа тавьдаг журмыг хатуу мөрдлөг болгож, итгэл алдсан тохиолдолд

- Өмчлээрийг усжуулах, худаг сэргээх, нээх зэргээр төрөөс мал аж ахуй эрхлэгчдийг хохүүлэн урамшуулж дэмжлэг үзүүлнэ.
- Дэд бүтэц сул хөгжсөн манай улсад МАА-н гаралтай бүтээгдэхүүнийг тухайн газарт нь хагас болон бүрэн боловсруулах нь эдийн засгийн хувьд хэмнэлттэй байдгийг нягт баталсан тул аль болох гүн боловсруулах жижиг үйлдвэрүүдийг олноор нь байгуулах нь эдийн засгийн болоод нийгмийн асуудлыг зэрэг шийдэх бололцоотой гэж үзэж байна.
- МАА-н чиглэлээр Монголын эрс гэс уур амьсгалтай нутагт сайтар зохицсон үүлдэр үүснэ бүхий өндөр шимт мал сүргийг мах, сүү, ноосны чиглэлээр тасралтгүй хөгжүүлнэ.
- МАА нь зуд болон ган гачиг болоход хамгийн их эмзгээр өртөж байдаг салбар тул бийгалийн гамшгийн эсрэг тэмцэх цэгцтэй бодлого боловсруулан, УИХ, ЗГ-аас бодит шийдвэр гаргуулахын төлөө байна. Мөн энэ чиглэлээр МАА-н төрийн даатгалын сан улсын төвлөрсөн төсвөөс гарааны санхүүжилтийг хийх журмаар шийднэ.

Газар тариалан

- Монголын цаг уур, хөрсний бүтэц зэрэгт онцгой тохирсон буудайн болон хүнсий ногооны үрийг бий болгох чиглэлээр АНУ, Канад, ОХУ, Европын зарим газар тариалан хөгжсөн орнуудтай нягт хамтран ажиллаж, 2002 оны хаврын тариалалтанд 60 хоногт 1га-аас 40-оос доошгүй центнер ургац авах нөхцөлийг бий болгоно.
- Монгол Улсын Хүнсний Аюулгүйн байдлын талаар шинэ хууль санаачилж, газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээж, эрчимт шатанд гаргах бүх талын дэмжлэгийг төрөөс үзүүлэх ёстой гэсэн байр суурийг хатуу баримтлана.
- Засгийн эрхэнд байгаа Канад, АНУ зэрэг хөгжилтэй орнуудын либерал чиглэлийн намуудын туслалцаатайгаар өнөөгийн БУУДАЙН САН-гийн үйл ажиллагааг шинэ шатанд гаргана. Мөн тухайн жилийн буудайн ургацаас 50 хувийг зах зээлийн үнээр буюу дотоодын таваарын улаан буудайн үнийг тогтмол барих, газар тариаланд ирилжааны банкуудаас авсан зээлийг найдвартай эргүүлж төлөх угтвар нөхцөлийг төр бүрдүүлж өгөх шаардлагатай. МЛАН нь энэ чиглэлээр улс төрийн байр сууриа УИХ-д баттай хамгаалах болно.
- Нэгэнт бэлэн болоод байгаа Газар тариалангийн заавал даатгуулах хуулийн төслийг Парламентын нам болсныхоо дараа УИХ-д өргөн барьж, тэргүүн ээлжинд хэлэлцүүлэхийг шаардана.
- Газар тариаланд орчин үеийн техник тоног төхөөрөмж, шимт бордоо, гербицидийг зах зээлийн хамгийн хямд үнээр тасралтгүй нийлүүлэхийг бүх талаар дэмжинэ.
- Газар тариалангийн чиглэлээр өрхийн фермерийн аж ахуйг Канад, АНУ-гийн ижил төрлийн фермерийн аж ахуйн жишгээр байгуулан сурталчилж, газар тариаланчдаа дэмжинэ.

Аж үйлдвэр

1. Хөнгөн аж үйлдвэр

- Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх талаар төр хүчтэй анхаарал тавьж, бодлогоор 89 мянган хүний ажлын байрыг 2000-2004 онд гаргана.
- Экспортонд аль болох төгс боловсруулсан бүтээгдэхүүн гаргаж, дэлхийн зах зээлд зохих байр сууриа эзэлнэ.
- Монгол улсад бий болсон хөнгөн үйлдвэрт суурилан, дотоодын зах зээлийг аль болох өөрийн бүтээгдэхүүнээр хангахыг эрмэлзэнэ.

2. Хүнд аж үйлдвэр

- Уул уурхайн салбарыг цаашид хөгжүүлэн, баяжмал гадаадад гаргахыг татварын аргаар зогсоож, энэ салбарт шат дараалсан хөрөнгө оруулалт хийн, эх орныг чирэгч үйлдвэрийн хэмжээнд хөгжүүлнэ.

- Төрийн өмч ба байгалийн баялаг ашигласны төлбөрийн орлогыг нэмэгдүүлэх
- Урьд нь хувьчилсан төрийн өмчийн ашиглалтыг шалгаж, гэм буруутанд хариуцагаа үүсгэн, дахин хувьчлал явуулах

4. Төрийн аппаратыг өөрчлөх ба авилгалтай тэмцэх

- Төрийн албаны түшмэдийн тоог цөөрүүлж, тэдний цалинг өсгөн, хариуцлагыг нэмэгдүүлэх
- Түшмэдийн шийдвэрлэхээр хуулинд тусгагдсан асуудлуудаас онцын шаардлагагүйг хүчингүй болгох
- Түшмэдийн шийдвэрлэдэг амьдралд хэвшээд байгаа улсын захиалга, бараа авах, хөрөнгө оруулалт, лиценз олгох гэх мэт асуудлыг өөрчлөх
- Асуудлыг хувиараа шийдвэрлэдэг түшмэдийн үйл ажиллагааг ил тодорхой болгон олон нийтийн хяналт тавих
- Авилгалыг үзэн ядах уур амьсгал бий болгон, авилгалын эсрэг тусгай хөтөлбөр гаргах
- Авилгалтай тэмцэх хуулийг боловсронгуй болгох

5. Мал аж үйлдвэрийг дэмжин хөгжүүлэх бодлогыг идэвхжүүлж, хөрөнгө оруулалтыг дэмжих

- Мал аж ахуйг хөгжүүлэх үндсэн хэлбэр нь "мал төрийн хамгаалалтад байх" Үндсэн Хуулийн заалтыг хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бий болгох
- Газар тариалангийн бүтээгдэхүүнийг улсад худалдан авах 10 тэрбум төгрөгийн нөөц бий болгосноор өрийн сүлжээг тайлж, зах зээлийн хомсдолыг арилгах
- Жижиг, дунд үйлдвэрлэлийг экспортын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр "инкубаторжуулах" аргыг нэвтрүүлэх
- Дэд бүтэц, бүс нутгийн хөгжлийг дэмжих чиглэлийн хөрөнгө оруулалтыг урамшуулах төрийн бодлого хэрэгжүүлэх

6. Мөнгө зээл, хөрөнгө оруулалтын оновчтой бодлого явуулах

- Арилжааны банк ашигтай байх бүх хувилбарыг хөхүүлэн дэмжиж, арилжааны банкны үйлчилгээг бизнесийн хүрээнээс хасч тооцох ба улмаар татвараас чөлөөлөн зөвхөн үйлчилгээний лицензийн тогтмол хураамж төлдөг болох явдлыг дэмжих
- Монгол улсын банк санхүүгийн дотоод Хар хайрцагны бодлогыг төрөөс боловсруулан, гадаадын банк болон сайгуудыг чөлөөтэй оруулж, хадгаламж эзэмшүүлэн мөнгө санхүүгийн эх үүсвэрээ зузаатгахыг дэмжих
- Үндэсний чирэгч үйлдвэрлэл-үйлчилгээ бий болгох зарчим баримтлан зээлийн бодлогыг түүнд зохицуулах, тухайлбал энэхүү ангилалд багтаж байвал үндэсний чирэгч үйлдвэрлэл-үйлчилгээнд удаан хугацааны зээлийг тэргүүи ээлжинд олгох шударга зарчмыг хэвшүүлэх
- Гадаадаас зээл авахдаа эн түрүүнд улсынхаа геостратеги, аюулгүй байдлыг урьдал болгож, зээл тусламжийн үр өгөөжийг хатуу тооцож байх тогтолцоог бүрдүүлэх
- Дотоодын үйлдвэрлэл нэгэнт хөгжсөн салбарт хөрөнгө оруулалт дахин хийхэд татварын илүү таатай нөхцөл бүрдүүлэх
- Гадаадын хөрөнгө оруулалтыг авахын өмнө дотоодын үйлдвэрлэгчийн нөхцөл байдлыг харгалзан, дотоодын хөрөнгө оруулагчид зээл санхүүгээс эхлээд бүх төрлийн дэмжлэгийг шат дараалалтай үзүүлдэг эрх зүйн орчин бүрдүүлэх
- Хөрөнгө оруулагчийг үнэлэхдээ тоо хэмжээгээр нь бус, чанарыг нь харгалзан үзэх шаардлагыг дэвшүүлэн ажил хэрэг болгоход тус тус чиглэгдэнэ.

Мал Аж Ахуй

- Малжуулах төслийг бүх талаар нь дэмжинэ.
- Эрчимжсэн мал аж ахуйн фермерыг улам олноор нь байгуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ.

- Монгол Улсын импортын цахилгааныг олон зах зээлээс импортлодог байх зарчим бий болгон, импортын цахилгааны үнэ тарифыг тасралтгүй бууруулна.
- Цахилгаан эрчим хүчийг гарган авахдаа зөвхөн нүүрсийг түшиглэх бус, мөн нар, салхи, ус болон бусад хэлбэрийг ашиглана. Ялангуяа, хөдөөгийн цахилгаанжуулалтыг мөн хэлбэрийн ба дизельтэй хосолсон байдлаар шийдэх болно.

Зам харилцаа

- Төр, олон улс ба улсын зэрэглэлтэй төмөр, авто, агаарын замын шугамыг өөрийн мэдэлдээ авч, цаашид хийх хөрөнгө оруулалт, өргөтгөл ба арчилгаа үйлчилгээг хариуцна.
- Монгол Улс сонгодог зах зээлд ортол аливаа замыг хувьчлах асуудал байж болохгүй.
- Шинээр зам тавих, агаарын шинэ шугам нээх асуудлыг нээлттэй байлгах ба чанарыг эрхэмлэнэ.

Мэдээлэл-Холбоо:

- Эх орны уудам нутагт нефть бүтээгдэхүүн импортлодог орны хувьд харилцаа холбоог дээд зэрэг хөгжүүлэх нь амьдралаас үүссэн хэрэгцээ мөн гэж үзнэ.
- Холбооны салбарт аль болох сүүлийн үеийн дээд эрэмбийн дэвшилтэт технологи ашиглан тоон системд улс даяар шилжинэ.
- Хөдөөгийн өрх нэг бүрт телевиз, радиогийн нэвтрүүлэг үзэж сонсох боломж бий болгох нь ардчиллыг улам гүнзгийрүүлэх алхам мөн гэж үзнэ.
- Монгол орон өөрийн саисарын станцыг түрээлсэн авч, сансарын холбооны технологийн глобалчлалыг угтан оролцож ашигтай байр суурь эзэлнэ.
- Мэдээлэл-Холбооны салбарт өрсөлдөөн үүсгэх байдлаар хувьчлалыг дэмжинэ.
- Интернет бол хүн төрөлхтөнд илгээсэн хоёр дахь гал гэж үзэж, дунд ба их дээд сургуулийг үнэ төлбөргүй Интернетэд холбож өгнө. Мөн ард иргэдэд Интернетийг өргөн сурталчилж, Монгол Улсын хүн амд үйлчилж байдаг үнэ төлбөргүй мэдээллийн сан үүсгэнэ. Нийгмийн хөгжлийг 2 дахин хөгжүүлэхийн тулд мэдээллийг 16 дахин хурдтай солилцох, тараах, авах боломжийг улс даяар жигд бий болгоно.

Нийгмийн хүрээнд тавих зорилтууд:

1. Хүн амын орлогыг нэмэгдүүлж, хөдөлмөрийн чадваргүй иргэдийн нийгмийн хамгааллын системийг бэхжүүлнэ. Үүнд:
 - Төсвийн байгууллагын ажилтны цалинг цаг тухайд нь олгох, цалин саатуулсан этгээдтэй эдийн засгийн хариуцлага тооцох, төлбөрийн чадваргүй этгээдээс ажиллагсдыг найдвартай хамгаална.
 - Үнийн өсөлттэй уялдуулан хүн амын орлогыг нэмэгдүүлж, хүмүүсийн амьдралын бодит төвшинг эрс унагахгүй байх
 - Хөдөлмөр хөлсний доод хэмжээг чинээлэг амьжиргааны түвшинд үе шаттайгаар ойртуулах
 - Төсвийн байгууллагын ажилтнууд, түүний дотор эмнэлэг, гэгээрлийн ажилтнуудын цалин хөлс, урамшууллыг бодит түвшинд хүргэх
 - Нийгмийн тэтгэвэр тэтгэмжийн хэмжээг чинээлэг амьжиргааны доод түвшинд үе шаттайгаар ойртуулах,
 - Хөдөлмөрийн чадваргүй хүмүүс, ялангуяа, хүүхэд, тахир дутуу иргэдийн нийгмийн баталгааны түвшинг мэдэгдэхүйц нэмэгдүүлэх
 - Өмч хувьчлалаас хохирч үлдсэн, амьжиргааны дунд болон дундаас доош төвшинд орсон иргэдийг орон байртай болгох зорилгоор тусгайлан улсын сан байгуулах

- Хүнд аж үйлдвэрээс дэлхийн зах зээлд өрсөлдөж чадах салбарыг түлхүү хөгжүүлэн, энэ салбарт тогтвортой ажиллагсдын тоог жил бүр нэмэгдүүлж, 2004 оны байдлаар шинээр 70 орчим мянган ажлын байр бий болгоно. Тухайлбал, нефть хими, хар ба өнгөт төмөрлөг боловсруулах, Үндэстэн дамнасан корпорациудтай хорших замаар өндөр технологи ашиглан дэлхийн зах зээлд шууд өрсөлдөх чадвартай бараа бүтээгдхүүн үйлдвэрлэнэ.
- Монгол Улсад хүнд аж үйлдвэрийн тодорхой салбарыг хөгжүүлэх концепци боловсруулан батлуулна. Мөн энэ ажлын хүрээнд 2020 хүртэлх **МОНГОЛЫН АЖ ҮЙЛДВЭР** гэсэн цогцолбор судалгааг явуулж, хөгжлийн стратеги тактик боловсруулна.

3. Худалдаа

- Дотоодын худалдаанд бүрэн либералчлал явуулах цаг болоогүй бөгөөд шилжилтийн энэ зурвас үе дуустал төрийн мэдэлд байхаар бодож үйлдвэрлэл эрхлэж чадахааргүй ирд иргэдийг худалдааны ашгаараа амьдрах боломж олгох болно.
- Гадаад худалдаанд хөрш хоёр оронтой тэргүүнд ээлжинд **ХУДАЛДААНЫ ТЭГШ ТҮНШЛЭЛ** бий болгохын төлөө төрийн дипломат шугамыг ашиглах бөгөөд Монголд үйлдвэрлэсэн бол хоёрдугаар зэрэгт орно гэсэн хуучирсан гадаад худалдааны системийг халж, оронд нь бүс нутгийн хэмжээнд гадаад худалдааг бүс нутагт либералчилах бодлогыг тэргүүлэн авч үзнэ.
- Монгол Улсын эдийн засгийн чадавхийг гадаад худалдааны сальдо болох тэнцлээр хэмжиж байх ил бөгөөд энгийн зарчмыг хэрэгжүүлж заншина. Мөн гадаад худалдааны сальдог аль болох эерэг болгон ашигтай байхаар экспорт/импортын балансыг барьж байна. Хэрэглэгч бол **ХААН** гэсэн зарчмыг энд алдагдуулахгүй байхыг гол болгох тул чөлөөт өрсөлдөөн байх ёстой гэж үзнэ.
- Дотооддоо үйлдвэрлэж экспортонд гаргаж байгаа бүтээгдхүүнд импортын өндөр татвар тавьж эхлэх бөгөөд зах зээлээ хамгаалах протекционист бодлогыг АНУ, Баруун Европын жишгээр шинээр бий болгон ажиллаж, дотоодын үйлдвэрлэгчдийг шууд хамгаалалтанд авна.
- Монгол Улсын гадаад худалдааны эргэлтийг 2000-2004 оны хооронд одоогийнхонтой харьцуулбал 3 дахин буюу түүнээс ч илүү дахин өсгөх боломжийг ашиглан хөгжүүлнэ.
- Монгол Улсыг бүс нутаг хамгийн том гадаад худалдааны эргэлттэй улс болгон өнөөгийн хямралт байдлаас богино хугацаанд гаргах боломжийг ашиглана.
- Импортын төлбөрт чөлөөт валютаа аль болох бага хэрэглэн **ДИСТРИБЬЮТОР, ФРАЙНЧАЙСИНГ, ЛИЗИНГ, ФАКТОРИНГ, НОУ-ХАУ** болон бусад гадаад худалдаа-олон улсын эдийн засгийн арга механизмуудыг ашилан, төлбөрийн баталгааг гарган өгөх хуулийг баталгаажуулна.
- Монгол Улсад барааны их хэмжээний нөөц бий болгон, гадаад худалдаа, түүний дотроос хөрөнгө оруулалт маш бага зарцуулдаг ре-экспортын бизнесыг төрийн бодлогын хэмжээнд авч үзнэ.

ДЭД БҮТЭЦ

Эрчим хүч:

- Эрчим хүчийг макро эдийн засгийн салбарт түлхүү хөгжүүлэх салбар болгохыг хуульчлан, Монгол Улсын Хөгжлийн Ерөнхий Үзэл баримтлалд тусгана.
- Цахилгаан, дулаан, үйлдвэрлэлийн уур үйлдвэрлэгчдийг элдэв төрлийн өрийн дарамтаас цогцолбор байдлаас гаргах аргыг ашиглах бөгөөд эдгээр 3 төрлийн бүтээгдэхүүнийг зах зээлд чөлөөтэй өрсөлдүүлж, хамгийн ашигтай хувилбарыг сонгохдоо зөвхөн хэрэглэгчдийн хэрэгцээгээр шийдэх зарчмыг баримтлана.
- Цаашид эрчим хүчээр хангагдах нөхцөлийг либералчилж хуваарилах буюу өндөр хүчдэлийн шугамаас бусад хэсгийг хувьчлах боломжийг судлаж шийднэ.
- Өнөөгийн эрчим хүчний төлбөр тооцооны ба бусад үрэлгэн байдлыг эцэс болгон, бүх шатанд тоолууржуулах бөгөөд хэмнэлтийн горимд ажиллаж сургах талаар хууль гаргахын төлөө байна.

Шинжлэх ухааны салбаруудаар юуны өмнө тэргүүлэх чиглэл, тусгай хөтөлбөрийн дагуу суурь, хавсарга судалгааг хөгжүүлж, сонголтыг оновчтой болгон, нийгэм-эдийн засгийн бодит хэрэгцээ захиалгад нийцүүлнэ.

Эрдэм шинжилгээний ажлын үр дүнг практикт нэвтрүүлэх асуудлыг эрхэлсэн банк санхүүгийн тогтолцоо бий болгоно.

Шинжлэх ухааны боловсон хүчин бэлтгэх, дадлагажуулах системтэй арга хэмжээ авна. Төр засаг, шинжлэх ухааны байгууллагууд, эрдэмтдийн хоорондын үйл ажиллагааны нэгт уялдаа интеграцчиллыг бүрдүүлнэ.

Эрдэм шинжилгээний ажил, монголын шинжлэх ухааны академийн статусыг өргөтгөнө.

Суурь судалгаа, зарим салбарт хавсарга судалгааны сай байгуулна.

Эрдэм шинжилгээний туршилтын үйлдвэрээс олсон орлогыг шинжлэх ухааныг санхүүжүүлэхэд зарцуулна.

Гадны хөрөнгө оруулалт, хамтын судалгаа, туршилтыг өргөжүүлнэ.

4.1. урлаг

Гүүх, соёлын ба музей, номын сангийн фондын дурсгалууд зэрэг үндэсний соёлын өвийг олшруулж, хадгалах арга хэмжээ авна.

Соёлын байгууллагуудын үйл ажиллагааг төр засгаас тусгайлан яам байгуулж удирдан зохион байгуулах хүртэл хэмжээнд төр засгаас дэмжих бодлого явуулна.

Урлагийн байгууллагад хөрөнгө оруулалт хийх, тус байгууллагын үйл ажиллагааны төлбөрийн системийг боловсронгуй болгох, татварын болон ёс суртахууны дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авна.

Соёл, урлагийн хүрээнд гадаад харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэхийг идэвхтэй дэмжинэ.

Үеийн тамир, спортын байгууллагуудыг санаачилгыг төсвөөс болон татварын хөнгөлөлтөөр дэмжих бодлого явуулна.

4.2. иргэний аюулгүй байдал

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг бүхий л талаар хангахыг эрхэмлэнэ.

Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хамгаалан бэхжүүлнэ.

Цэргийн шинэтгэлд бүтцийн болон чанарын өөрчлөлт хийх замаар орчин үеийн шаардлагыг хангасан мэргэжлийн чадварлаг зэвсэгт хүчин, бусад цэрэгтэй байхын төлөө байна.

Зэвсэгт хүчний болон бусад цэргийн үүрэг гүйцэтгэх чадавхийг олон улсын энхийг сахиулах хүчний алба ажиллагааны шаардлагын түвшинд хүргэнэ.

Төрийн хилийн бодлогын үндсийг боловсруулж, энэ үндсэн дээр улсын хилийн батлан хамгаалалтын нэгдсэн сүлжээг байгуулна.

Орчин үеийн шаардлагыг хангах хил хамгаалалтын иж бүрэн арга хэмжээг хэрэгжүүлснээр хил хамгаалалтыг бэхжүүлнэ.

Таниуулын байгууллагын бие даасан тогтвортой байдлыг бэхжүүлж, хуулийн дагуу идэвхтэй, эрчимтэй цогц үйл ажиллагааг явуулснаар мэдээллийн болон шуурхай ажиллагааг улам сайжруулна.

Гадаад бодлого

Монгол улс хүчтэй, хүчирхэг байхын үндсэн нэг нөхцөл нь гадаад хүчин зүйлтэй саншгүй холбоотой. Гадаад бодлогыг үндэсний эрх ашигт нийцүүлэн явуулна. Дотоод бодлогын амжилт гадаад бодлогод шууд нөлөөлөхийг үндэс болгоно.

Олон улсын тавцанд үндэснийхээ эрх ашгийг хамгаалж, гадаад улс орнуудтай эрх тэгш, нэгцвэртэй найрсаг, хамтын ажиллагааны харилцааг өргөжүүлэх үндсэн дээр Монгол Улсын

Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хороонд ардчиллын уур амьсгалыг бэхжүүлж, үйлдвэрчний байгууллагууд, эздийн байгууллагуудын өргөн толооллийг бүрдүүлснээр хөдөлмөр эрхлэгчдийн зөрчигдөж байгаа эрх ашгийг бүрэн хамгаалах нийгмийн эрүүл тогтолцоог бий болгох

Дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалттай үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд ажиллагсдын эрх ашиг хохирох явдал гаргуулахгүй байх, ялангуяа үйлдвэрлэлийн салбарт хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг бий болгох үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх

Идуурал, ажилгүйдлийг бууруулах талаар үр нөлөөтэй арга хэмжээ авна.

Хувиараа бизнес эрхэлдэг иргэдийн хөдөлмөрлөх болон бусад эрхийг хамгаалж бэхжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авна.

Эрүүл мэнд

Өвчтөнд эмнэлгийн тусламж үнэ төлбөргүй үзүүлнэ (мэргэжлийн зөвлөлгөө, эм материал, түргэн тусламж гэх мэт/

Хилдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх системийг бий болгоно.

Доноруудад санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

Эмч, нарийн мэргэжлийн мэргэшлийг дээшлүүлэх, бэлтгэн гаргах систем бий болгоно.

Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх бодлого боловсруулан, ард түмний тусын тулд өргөн ашиглана.

Боловсрол

Оюуны шавхагдашгүй нөөцийг манай орны хөгжлийн гол хөдөлгөгч хүч болгоход төрийн бодлогыг чиглүүлнэ.

Боловсролын байгууллага нь бие даасан бөгөөд төрийн ивээл дор байна.

Боловсролын бодлогыг нээлттэй, ил тод болгох, боловсролын байгууллага болон суралцагчдад тавигдах шаардлага болон тэр дундаа элсэлтийн шалгалтанд тавигдах шаардлагыг нээлттэй болгоно.

Боловсролын макротүвшинд либералчлах, микротүвшинд прагматчлах бодлогыг суралцагчдын эрэлт хэрэгцээг бүрэн дүүрэн хангах чиглэлд тууштай баримтална.

Дэлхийн боловсролын шилдэг арга, технологи болон монгол ардын сурган хүмүүжүүлэх өв уламжлалд суурилсан сургалтын технологийн шинэчлэлтийн бодлого баримтална.

Оюуны чадавхи сайтай хүүхдүүдийг бүх шатны сургуульд үнэ төлбөргүй сургах механизмыг бүрдүүлнэ.

Боловсролын байгууллагад ажиллагсдын цалинг төсөвт цалингийн дээд түвшинд ямагт байлгаж, тэдний нийгмийн асуудлыг төрөөс баталгаажуулна.

Шинжлэх ухаан

Аливаа орны тусгаар тогтнол, хөгжил дэвшлийн баталгаа болсон шинжлэх ухааныг онцлон үзэж, түүнийг идэвхтэй хөхүүлэн дэмжинэ. Үүний тулд:

• Шинжлэх ухаанд зарцуулах улсын төсвийн зардлын хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.

• Эрдэм шинжилгээний ажлын захиалагч болон гүйцэтгэгчдэд татварын хөнгөлөлт үзүүлдэг болно.

• Шинжлэх ухааны хүрээнд бий болсон жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжинэ.

• Монгол Улсын шинжлэх ухааны олон улсын интеграци болон иргэний шинжлэх ухааны нийгэмлэгүүдийг хөгжүүлэх явдлыг дэмжинэ.